

Төвөд хэлний “Сог” болон “Согбо” хэмээх үгсийн утгыг мөшгөхүй

Норовын БАТСАЙХАН*

Монгол Улс, Улаанбаатар,
Анагаахын Шинжлэх Ухааны Үүдэсний Их Сургуулийн харьяа
Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургуулийн
Монгол уламжлалт анагаах ухааны хүрээлэн

Received: May 21, 2024**Revised:** Sep 20, 2024**Accepted:** Oct 04, 2024

Хураангуй: Энэхүү судалгаагаар төвөд хэлний “Сог” болон “Согбо” гэсэн үгсийн илэрхийлэх утгыг тодруулах зорилгоор XII зууны эхэн үеэс өнөөг хүртэл бүтээгдсэн зарим төвөд эх сурвалжууд болон бусад судлаачийн бүтээлд харьцуулан дүн шинжилгээ хийлээ. Үүний үр дүнд эдгээр үгс нь эрт цагаас эхлээд барагцаагаар XVII зууны эхэн хүртэл Төвөдөөс баруун болон хойд зүгт орших зарим ард түмнүүд ялангуяа Иран гарал бүхий Скиф (Сака), Согд зэрэг аймгуудыг голчлон нэрлэж байжээ. Харин Хошуудын Төрбайх ноён Хөх нуурын бүс нутаг, улмаар Төвөдөд хяналтаа тогтоосон цаг үеэс Монгол болон монголчуудыг эдгээр нэр томъёогоор нэрлэх болсон байна. Эдгээр үгсийн илэрхийлэх утгыг Монгол болон монголчуудын түүхтэй хамаарагдах мэдээллүүдтэй холбон тайлбарлахдаа тухайн үеийн түүхийн цаг хугацаа, орон зайд нь ойлгож, судлах болон монголын уламжлалт анагаах ухааны түүхийн үечлэлийн асуудлыг ч эргэн хянах зайлиггүй шаардлагатай тулгарч байна.

Түлхүүр үг: Монгол хануур, гавлын яс нүхлэх, уламжлалт анагаах ухаан, монгол эмч, Монголын эзэнт гүрэн, Скиф, Согд

Tracing the Meaning of the Tibetan Words “Sog” and “Sogpo”

BATSAIKHAN Norov

Institute of Mongolian Traditional Medicine,
International School of Mongolian Medicine,
Mongolian National University of Medical Sciences,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: To clarify the meaning of the word “Sog” and “Sog po” in the Tibetan language, the study analyzed a number of Tibetan sources from the early

* © Н.Батсайхан 2024Email: bsaikhan4@gmail.com

12th century to the present, as well as the works of other scholars. As a result, from early times until the beginning of the 17th century, certain peoples in the west and north of Tibet, especially the Scythians (Sakas) and Sogdians of Iranian origin, were primarily mentioned. However, after Khoshut Turbaikh khan gained control over the Blue lake region and Tibet, these terms began to be used to refer to Mongolia and the Mongols. When explaining the meaning of these terms in connection with the history of Mongolia and the Mongolian people, it is essential to understand and study them within the historical context of that period. Additionally, the periodization of the history of Mongolian traditional medicine should be carefully reviewed.

Key words: *Mongolian bloodletting treatment, Trepanation, Traditional medicine, the Mongolian doctor, the Mongolian Empire, Scythia, Sogdian*

1. Удиртгал

Орчин үеийн төвөд хэлнээ “Сог” болон “Согбо” гэсэн нэр томьёо нь ихэнх тохиолдолд Монгол, монголчууд, зарим тохиолдолд Төвөдөөс баруун зүгт орших улс, хүмүүс гэсэн утгыг илэрхийлдэг. Тухайлбал “Төвөд-монгол толь”-д “сог” гэдэг нь 1. хураах цуглуулах, 2. Монгол гэсэн утгатай бол “согбо” нь 1. Монгол, Сартуул, 2. Шарайгол, Төвөд, Тангадын хойдох Монгол, Түрэг, Татаар (Бүрнээ, Энхтөр, 2006: 504) гэсэн утгыг илэрхийлдэг гэжээ. Түүнчлэн түүхийн зарим зохиолд Согтаг, Хорсог гэх мэт сог гэсэн үг оролцсон нийлмэл үгс тааралддаг. Монголын эзэнт гүрэн байгуулагдахаас өмнөх үеийн Төвөдийн бичгийн эх сурвалжуудад “сог” болон “согбо” хэмээх үгс цөөнгүй дурдагдах бөгөөд орчин үеийн монголын уламжлалт анагаах ухааны түүх бичиглэлд дээрх орчуулгуудын Монгол, монголчууд гэсэн утгыг баримталснаар Төвөдөд уригдан ирсэн согбо эмч Галеносын ахмад хүү, их Ютог Ёндонгомботой ном хаялцсан согбо эмч Налашандарба, хүзүүний шарх эмчлэх номыг сангаас гаргасан согбо эмч Жанчив гэх мэт хүмүүсийг монгол хүмүүс байсан гэх буюу “сог” нарын эмчилгээнд хэрэглэж байсан хануур заслыг монголчууд зохиосон гэж бичих нь монгол хэвлэлүүдэд (Болд, 2006: 71-74; Болд., Жавхлан нар, 2020: 36-45) түгээмэл тааралддаг. Хэдий тийм боловч Төвөдөөс баруун зүгт орших улс, хүмүүс гэсэн нөгөө утгыг нь мухарлалгүй орхигдуулах нь монголын уламжлалт анагаах ухааны түүх үнэн зөв бичигдэж буй эсэхэд эргэлзээ дагуулж байна. Тиймээс энэхүү өгүүлэлд төвөд эх сурвалжуудад дурдагдах эдгээр үгсээр төвөдүүд МЭ 600 он орчмоос 1600-аад оныг хамрах мянга гаруй жилийн хугацаанд аль улс, ард түмнийг нэрлэж байсан болохыг тодруулахыг зорьсон болно.

2. Судалгааны арга, хэрэглэгдэхүүн

Уг судалгаанд төвөд хэлээр бичсэн зохиолуудад тааралдах “сог” болон “согбо” хэмээх үгс, үүнтэй холбоо бүхий мэдээллүүдийг агууламжийн судалгааны (content analysis) аргаар түүвэрлэв. Харолд Лассвэл¹ (1949)-ийн нэвтрүүлсэн энэхүү арга нь асар их хэмжээний бичиглэл дэх үгсийн чиг хандлага, хэв маяг, давтамж, тэдгээрийн харилцаа холбоо зэргийг тодорхойлоход өргөнөөр ашиглагддаг, системтэйгээр кодолж, ангилах

¹ Harold Lasswell

судалгааны арга юм (Попе² ба бусад., 2006: 63-81). Түүвэрлэсэн мэдээллээ тухайн үеийн түүхэн үйл явдлуудтай харьцуулан судлах аргаар боловсруулалт хийлээ.

Уг сэдвийн хүрээнд Сажа бандида Гунгаажанцан (1182-1251)-ы шавь нартаа бичсэн захидал, Вранди Балдан Цожэд (1310-1380)-ийн “Билгүүнийг тодруулагч”, Содномжанцаны “Хаадын удам судрыг тодорхой үзүүлэгч толь”, Дарма маарамба Лувсанчойдогийн туурвисан “Их Ютог Ёндонгомбын Намтар”, Дэсрид Санжайжамц (1653-1705)-ын *Хог Вүг*, Зая бандида Лувсанпэрэнлэй (1642-1715)-н бүрэн зохиолын Ка боть зэрэг эх сурвалжууд болон бусад эрдэмтдийн бүтээлийг судалгааны хэрэглэгдэхүүнээр ашиглалаа.

3. Судалгааны хэсэг

3.1. “Сог” болон “сogбо” гэсэн үгсийн илэрхийлэх утга ба монголын уламжлалт анагаах ухааны түүхчдийн эдгээр үгсийг орчуулах хандлага

Эдгээр үгсийн илэрхийлэх утгыг олонх толь бичиг болон эрдэмтэд дараах байдлаар тайлбарладаг. Тухайлбал, Сумадирадна³-гийн толь бичигт *сogбо* хэмээх үгийг Монгол, Сартуул, Шарай гол, Төвөд Тангадын умард байх Монгол гэсэн утгаар тайлбарласан байна (Sumadiratna, 1959: 1193). О.Сүхбаатарын бичсэн “Монгол хэлний харь үгийн толь”-д Сог(во) хэмээх үгийн тайлбарт “Төвөдчүүд Монголыг ийн нэрлэж ирсэн нь монгол бичгийн дурсгалд оржээ” гэжээ (1997: 169). Төвөд хэлний цахим тайлбар тольд⁴ *сogбо* гэсэн үг нь монголчууд болон согдуудыг нэрлэнэ гэсэн бол Баатр Китинов⁵ Согд, Уйгар, баруун Монголчуудыг *сogбо* хэмээн нэрлэдэг (1996: 35-46) гэж тодорхойлжээ. Жиродү⁶ ба Горэ⁷ нар өмнөд Хамын төвөдүүд монголчуудыг *сogбо* гэх ба *сogбо гонма*⁸ “Монгол эсвэл Манж эзэн хаан” (1956: 185) хэмээн тайлбарласан жишээгээр төвөдүүд манж нарыг ч зарим тохиолдолд *сogбо* хэмээн дууддаг гэж үзжээ. Олонх эрдэмтэд төвөдүүд эрт цагт *сog* гэдэг нэр томъёогоор Төвөдөөс баруун зүгийн улс орнуудыг, тухайлбал Персийг *Согбо* Дагсиг⁹, Туркийг *Согбо* Дүрүка¹⁰ гэж нэрлэдэг (Жан¹¹, 1985: 2961) гэдэгт санал нэгддэг байна. Түүнчлэн, Ахмад¹² (1970: 110), Туччи¹³ (1999: 128, 256) нар “*хор*”¹⁴ болон “*сog*” гэдэг нь монголчуудыг өөр зуур нь ялгасан нэр гэсэн бол өөрсдийгөө “*хор*” гэж нэрлэх Төвөдийн Хам гэдэг газрын оршин суугчид

² Pope

³ Sumadiratna

⁴ <http://www.thlib.org/reference/dictionaries/tibetan-dictionary/translate.php>

⁵ Baatr Kitinov

⁶ Giraudeau

⁷ Goré

⁸ sog po gong ma

⁹ sog po stag gzig

¹⁰ sog po du ru ka

¹¹ Zhang

¹² Ahmad

¹³ Tucci

¹⁴ Энэ үгийн илэрхийлэх утгын талаар удахгүй хэвлэгдэх “Төвөд хэлний хор, хорба хэмээх үгсийн утгыг мөшгөхүй” хэмээх өгүүлэлд хэлэлцэх болно.

Монголчуудыг “хор” гэж хэзээ ч дууддаггүй бөгөөд өөрсдөөсөө ялгахын тулд “сog” гэдэг (Лхундроп¹⁵ ба бусад, 2019: 17-48) хэмээжээ.

Харин эдгээр үгсийн монгол, монгол хүн гэсэн утгыг баримтлах нь өнөө цагийн монголын уламжлалт анагаах ухааны түүхийн бичиглэлд зонхилон таардаг. Тухайлбал, Дарма маарамба Лувсанчойдог (1638-1710)-ийн зохиосон “*Их Ютог Ёндонгомбын намтар*” бүтээлд бичсэнээр Тэсриндэнзин (МЭ 742-797)-гийн хаанчлалын үед Төвөд орноо олон улсын эмч нарын цугларалт болсон бөгөөд хөрш зэргэлдээ Энэтхэг, Кашмир, Дагсиг, Түрэг, Балба, Хятад зэрэг улсуудаас төлөөлөгчид иржээ (Лувсанчойдог, 50а). Уг мэдээллээс академич Ш.Болд¹⁶ энэ цуглаанд хүрэлцэн ирсэн Дагсигийн *сogбо* Налашандирыг монгол хүн байсан бөгөөд Дагсиг гэдэг нь Хүннү нарын өөр нэр (2006: 122) гэж нотлохыг оролджээ. Түүнчлэн, уг номд эмчилгээний нэг төрөл болох хануур заслын аргын талаар “*Согийн ёсонд өвчнийг гадагш татах хануурын үндэс*” (Лувсанчойдог, 48б) хэмээн бичсэнээс үүдэн манай зарим судлаачид хануурыг дорно дахины эмчилгээнд монголчуудын оруулсан томоохон хувь нэмэр (Болд, 2006: 73) хэмээн тодорхойлсоор ирсэн. Түүнчлэн монголын уламжлалт анагаах ухааны түүхийг зургаан үе шатад хуваасны хоёр дахь үе буюу “эмнэлгийн тусламжийн туршлага хуримтлагдаж, анагаагч эмч бий болсон үе” гэсэн хэсэгт дээр дурдагдсан хануур заслын эмчилгээ, эмч Налашандир, “хор” нүүдэлчин эмч Бигүда, Лэгбажалцан нарын зэрэгцээ *сogбо* эмч нар болох Баяха, Жанчив болон монголоор нэрлэгдсэн перс эмч Галэйнойн хүү зэрэг төвөд эх сурвалжуудад *сogбо* гэж тодотгогдсон цөөнгүй хүмүүсийн (Болд, 2006: 93-128) тухай мэдээллийг хөгжлийн тухайн үе шатны монгол эмнэлгийн жишээ болгон авч үзжээ.

Тиймээс дараах дэд бүлгүүдэд эдгээр нэр дурдагдсан хүмүүсийн уг гарал, тухайн цаг үед зохиогдсон болон хийгдэж байсан зарим эмчилгээнүүдийг Монголчууд хийж байсан эсэхийг холбогдох эх сурвалжууд болон бусад судлаачдын судалгааны үр дүнтэй харьцууллаа.

3.2. Төвөдийн Сронзанганбын хаанчлалын үед холбогдох мэдээлэл

Бидний олж тогтоосноор ямар улс, хүмүүсийг *сog*, *сogбо* гэж нэрлэж буй нь одоогийн байдлаар анхны гэж хэлж болохуйц нэгэн баримт цаг хугацааны хувьд Сронзанганбо¹⁷ (617-650) хааны үетэй холбогдож байна. Уг мэдээлэл Сажа лам Содномжанцаны “Хаадын удам судрыг тодорхой үзүүлэгч толь” хэмээх зохиолд байх ба уг бүтээлийн бичигдсэн цаг хугацаа маргаантай байдаг. Тухайлбал, судлаач Лауфер¹⁸ 1327, Б.И. Кузнецов 1368 оны орчим, Тучи¹⁹ 1508, А.И. Востриков 1478 онд гэж янз бүрээр тодорхойлжээ (Хьюстон²⁰, 1974: 209-16). Харин уг номын “Хятад, Монгол оронд дээдийн ном дэлгэрсэн нь” бүлэгт монголын хаадыг Чингис хааны өвөг Бөртэ чоноос эхлэн Юань гүрний сүүлийн

¹⁵ Lhundrop

¹⁶ “Монголын анагаах ухааны түүх” номын бүх дахин хэвлэлүүдэд ижил бичигдсэн тул 2006 онд хэвлэгдсэн анхны хэвлэлийг энэ өгүүлэлд хэрэглэлээ.

¹⁷ strong btsan sgam po

¹⁸ B.Laufer

¹⁹ G.Tucci

²⁰ Houston

Тогоонтөмөр хааныг хүртэл (Содномжанцан, 29-32) нэрлэснээс үзвэл уг бүтээл ямар ч байсан 1368 оноос хойш бичигджээ.

Энэ зохиолд “Согбо болон Ли орон нь хөллөсөн тэрэг адил”, “Хор болон Хятад орон дэлбээлсэн бөлбөө цэцэг адил” (Содномжанцан, 6) хэмээн улс орнуудыг нүдэнд харагдаж, сэтгэлд буухуйц бодит зүйлстэй адилтган өгүүлснээс үзэхэд Содномжанцан уг бүтээлийг туурвиж ахуй үед “*хор*” болон “*сog*” гэсэн хоёр үгс өөр өөр улс орныг нэрлэж байсан нь илт ажиглагдана. Мөн уг бүтээлд:

“Зүүн зүгийн Хятад, Тангадаас урлахуй ухаан болон зурхайн ухааныг авсан. Өмнө зүгийн Энэтхэгээс дээдийн номын хөрвүүлэг авсан. Баруун зүгийн Сог, Балбаас хоол хүнс болон эд агуурс бэлтгэх мэдлэг авсан. Хойд зүгийн Хор, Уйгараас хууль ёс болон ажил хийх загвар авсан” (Содномжанцан, 92)

гэсэн нь тааралддаг.

Үүнээс үзэхэд *сog* хэмээх нэршил нь тухайн үед төвөдөөс хойд зүгт орших Монгол, Түрэг, Уйгур гэх мэт улс орныг заагаагүй харин баруун зүгийн улс орон болох нь илэрхий. Үүний зэрэгцээ уг бүтээлд есөн давхар өндөр байгууламжийг “Согбо загварын байшин” хэмээн нэрлэсэн гэх мэтээр “*Сог*” хэмээх нэрийг хэдэнтээ дурджээ. Энэхүү эх сурвалжийг Хоффман²¹ түүхэн баримтуудтай харьцуулан судлаад, *Сог* гэдэг нь МЭӨ IX зуунаас МЭ V зууны орчим оршин байсан хэмээн түүхэнд тэмдэглэгддэг зүүн Ираны Сака хэмээх нүүдэлчин аймгийнхныг заасан нэр (1971: 440-455) хэмээн тайлсан байдаг. Тухайн үеийн Грек, Вавилончууд Алтайн нуруунаас Хар тэнгис хүртэлх өргөн уудам нутагт амьдарч байсан зүүн Иран гарал угсааны хүмүүсийг, ялангуяа дорно хэсгийн нүүдэлчдийг Сака, өрнө хэсгийн нүүдэлчдийг Скиф гэж нэрлэдэг байв. Өнөө үед тэднийг Скиф хэмээх нийтлэг нэрээр нь дуудах болжээ.

Скифүүдийн үлдээсэн түүхийн дурсгал тэдний тархан амьдарч байсан газруудад цөөнгүй үлдэж хоцорсон бөгөөд археологичид Алтайн нуруу орчмоос илэрсэн Пазирикийн, Тагарын болон Чандманы олдвор зэрэг соёлын дурсгалыг тэдэнд хамааруулан авч үздэг. Скифүүдтэй холбогдох анагаах ухааны олдворуудын хувьд тэдний толгойн яс цоолох мэс ажилбар судлаачдын сонирхлыг ихээр татдаг юм. Жишээ нь, пазирикийн соёлоос илэрсэн, зориудаар цоолсон нүх бүхий гавлын яснуудыг оросын эрдэмтэд судлаад тухайн ажилбарын дараа тэдгээр хүмүүсээс амьд үлдсэн тохиолдол өндөр хувьтай байгааг илрүүлжээ (Алексей²² болон бусад, 2014: 649-655).

Мөн ийм төрлийн мэс ажилбар хийсэн ул мөр бүхий толгойн яснууд Увс аймаг дахь Чандманы соёлоос олдсоныг өвөг Монгол аймгууд тархины мэс засал хийж байсны илрэл (Болд, 2006: 83) гэж манай зарим судлаачид тодорхойлдог нь дээрх эрдэмтдийн нотолгооноос зөрөөтэй байдаг. Хэдийгээр уг олдворууд өнөөгийн Монгол улсын нутаг дэвсгэрээс олдсон хэдий ч, түүхийн янз бүрийн цаг хугацаанд Скиф, Түрэг, Уйгур зэрэг Монголоос өөр янз бүрийн овог, аймгууд энэ нутагт оршиж байсныг харгалзан үзэлгүйгээр түүхэн эд өлгийн зүйлсийг зөвхөн өнөөгийн оршин суугчдад хамаатуулах нь монголын

²¹ Hoffmann

²² Alexey.L

уламжлалт анагаах ухааны түүхийн зарим тодорхой цаг хугацааны хөгжлийг буруугаар тайлбарлах нэг нөхцөл болж байна.

Түүнчлэн Сронзанганбо хаантай холбоо бүхий өөр нэгэн мэдээлэл анагаах ухааны бүтээлүүдэд тохиолддог. Тухайлбал, Зая бандида Лувсанпэрэнлэй (1642-1715)-н өгүүлснээр Төвөдийн хааныг эмчлэхээр энэтхэгийн эмч Бхарадважа²³, хятадын эмч Хэн Вэн Ханди²⁴, дагсиг буюу ромын эмч Галэнас²⁵ нар ирсэн ба тэд “*Үл аюухуйн зэвсэг*”²⁶ нэртэй номыг хамтран бүтээжээ. Улмаар Галэнас Төвөдөд суурьшин үлдэж, гурван хүүтэй болсны том хүүг нь төвөдүүд “*сого* эмч”, бага хүүг нь “*бижи* эмч” гэж дуудах болсон байдаг (Лувсанпэрэнлэй, Ка боть, 78b). Энд дурдагдсан *бижи* гэх нэр томьёо төвөдийн өөр бусад эх сурвалжуудад ч цөөнгүй тааралдана.

Тухайлбал, Дэсрид Санжайжамцын *Хогвуг* зохиолд “Ром улсаас ирсэн, тэдний хэлээр бижи гэж дуудагддаг эмч Замбашилаха” хэмээх нэгэн хүний орчуулсан олон зохиолын талаар бичжээ (1982: 153-154). Эх сурвалжуудад дурдагдсан *бижи* гэдэг үг чухам ямар хэлний үг болохыг олж мэдэх нь тэдгээр эмч нарын уг гарлыг тогтооход чухал түлхүүр болох нь дамжиггүй. Харин энэхүү “*бижи*” гэсэн үг нь согд хэлний *бүс*- буюу эмч гэсэн утгатай үг болохыг Бэквит²⁷ (1979: 305) тогтоосон нь түүхийн энэ цаг үед *сого* гэж нэрлэгдсэн хүмүүс нь согд хүмүүс байж болох тухай бидний дэвшүүлж буй санааг батлах чухал нотолгоо болж байна.

Түүнчлэн уг зохиолд дурдагдсан хятадын Хэн Вэн Ханди хэмээх эмч нь хятадын анагаах ухааныг үүсгэн бий болгосон, *Нэйжин* хэмээх алдарт бүтээлийг бичсэн Шар эзэн хаан²⁸ мөн бөгөөд Энэтхэгийн Бхарадважа хэмээгч нь энэтхэгийн анагаах ухааныг үүсгэгч хэмээн тооцогддог “*Bharadvāja*”, харин Дагсиг буюу ромын эмч Галэнасыг өрнийн анагаах ухааныг үндэслэгч эртний Грекийн алдарт эмч Галенос болохыг судлаачид тодорхойлсон. Төвөд анагаах ухааны зохиолуудад тэдний нэрийг ийнхүү дурдсан нь уг эмнэлгүүдээс ирсэн нөлөөллийг үүсгэн байгуулагчдын нэрээр нь төлөөлүүлэн илэрхийлсэн гэж үзжээ (Бэквит, 1979: 297-313).

Эдгээр баримтаас дүгнэхэд эртний грекийн анагаах ухааныг үндэслэгч Галений нэг хүүг цоллодог согд хэлний “*бижи*” буюу эмч гэсэн үг болон түүний дагсигээс ирсэн гарал угсааг бодолцон үзвээс түүний өөр нэгэн хүү *сого* эмч, мөн *бижи* эмч Замбашилаха нарыг монгол хүн байсан гэж үзэх үндэслэл үгүй болох нь илэрхий байна.

3.3. Дунхуаны агуйгаас олдсон баримтууд (VI-XI зуун)

Сог хэмээх үг дурдагдсан дараагийн эх сурвалж бол Хятад улсын Дунхуан агуйгаас олдсон бичвэрүүд юм. Энэ олдворт *Сог* нар Төвөдийн эзэнт гүрний Гар овгийн өндөр албан тушаалтныг 694 онд баривчилсан тухай бичсэн

²³ Bharadvāja

²⁴ Hen-wen hang-de

²⁵ Ga le nas

²⁶ mi ‘jigs pa’i mtshon

²⁷ Beckwith

²⁸ Hsuan yuan Huan ti

байдаг ажээ (Бэкот²⁹, 1940: 38). Хэдийгээр Бэкот бүтээлдээ “сog” гэсэн үгийг Монголчууд гэж орчуулсан боловч бусад судлаачид (Хоффман,³⁰ 1971: 440-455) тухайн үеийн үйл явдлыг түүхийн бусад эх сурвалжтай харьцуулж судалсны үндсэн дээр Согдууд байсан хэмээн нотлох болжээ. Тухайлбал, өнөөгийн Шинжааны нутагт Согдуудын байгуулсан суурин газруудыг булаалдан 670 оноос хойш Төвөд Хятадын хооронд хэд хэдэн удаагийн дайн болсон ба энэ үед Хятадын талд байсан Согдууд 694 оны орчим Гар овгийн түшмэлийг баривчилсан болохыг Фан³¹ (1957: 141) тогтоосон байна.

Согдууд иран хэлээр ярих бөгөөд МЭ VI-X зуунд Дундад Ази буюу өнөөгийн Узбеки, Тажик зэрэг газар нутагт төвлөрөн (Вайссьер³², 2005: 16) зарим хэсэг нь өнөөгийн Шинжаан, Өвөрмонголд суурьшиж (Эдвин³³, 1952: 317-356) худалдааны үйл эрхэлж байлаа. Согдууд эртний Иранд байгуулагдсан Персийн анхдугаар эзэнт гүрэн (МЭӨ 550 - МЭӨ 330) Ахеменидийн улсын харьяанд байсан ба дараа нь агуу Александрын (МЭӨ 356 - МЭӨ 323) эзлэн дагуулалтаар Македоны улсын харьяалалд ч багтаж байв. Алдарт торгоны зам дагуу байрлан өрнө дорныг холбон худалдаа наймаа хийж ихэд хөлжиж байсан Согдууд энэ бүс нутгийн хооронд мэдээлэл дамжуулахад голлох үүрэгтэй байлаа (Батсайхан, 2021: 25-26). Согдуудын талаар алдарт түүхч Зава Дамдин бүтээлдээ *Согтаг*³⁴ нэрээр бичсэн байдаг. Тухайлбал, Согдууд Бурханы болон мани шашины зэрэгцээ “арьсны хэдрэг” мэт босоо бичгээ Монголд дэлгэрүүлсэн (Лувсандамдин, 1964: 27а-27б) тухай бичсэн байна.

Энэ өгүүллийн 3.2 ба 3.3 дэд бүлэгт өгүүлсэн баримтуудаас дүгнэхэд төвөдийн эх сурвалжууд дахь МЭ 600-700 оны хооронд холбогдох түүхэн үйл явдлуудад таарах “сog” хэмээх үгсийг *Монгол* хэмээн орчуулах үндэслэлгүй болох нь тодорхой байна.

3.4. Төвөдийн алдарт оточ их Ютог Ёндонгомботой холбогдох мэдээлэл

Цаг хугацааны хувьд “сog” хэмээх үгтэй холбоо бүхий мэдээллүүд төвөдийн их оточ Ютог Ёндонгомбо (МЭ 708-833)-той холбогдоно. Тухайлбал, Дарма маарамба Лувсанчойдог (1638-1710)-ийн туурвисан “*Их Ютог Ёндонгомбын намтар*”-т *сogбо* эмч Налашандирын (Лувсанчойдог, 50а) тухай бичсэнийг бид өмнө дурдсан. Энэхүү Налашандир эмчийн тухай Вранди Балдан Цожэд (1310-1380) Дарма маарамбаас 300 гаруй жилийн өмнө буюу 1372 оны орчим туурвисан “*Билгүүнийг тодруулагч*” хэмээх номдоо Халашандир (Вранди Балдан Цожэд³⁵, 2005: 77-80) гэсэн бол уг намтартай бараг нэгэн үед бичигдсэн Дэсрид Санжайжамцын (1686) *Хог Вүг* хэмээх зохиолд дагсигийн Халашанди эмч (Санжайжамц, 1982: 169) гэсэн байдаг. Халашандир эмчийн уг гарлыг олон улсын эрдэмтэд монголчуудтай холбож үздэггүй. Жишээлбэл, судлаач Бэквит³⁶ баруун Туркестанаас ирсэн араб

²⁹ Bacot

³⁰ Hoffmann

³¹ Fang

³² Vaissière

³³ Edwin

³⁴ sog thag

³⁵ brang ti dpal ldan 'tsho byed

³⁶ Beckwith

гаралтай (1979: 305) гэж бичжээ. Дээрх түүхэн сурвалжуудад Дагсиг буюу Перс (Иран)-ээс ирсэн *согбо* эмч Налашандирыг монгол хүн байсан гэж хэлэх үндэслэл уг үйл явдал болсон цаг хугацааны хувьд үгүй болох нь бидний өмнөх хэсгүүдэд хэлэлцсэн баримтуудаас тодорхой байна.

Түүнчлэн Лувсанчойдогийн бүтээлд хануур эмчилгээний тухай бичих үед *сог* хэмээх үг дахин тохиолдох ба согийн ёсны эмчилгээ хэмээн тодорхойлсон байдаг (Лувсанчойдог, 486). Хануур эмчилгээг Монголчуудын дорнын анагаах ухаанд оруулсан томоохон хувь нэмэр хэмээн манай зарим судлаачид үздэг тухай бид удиртгал хэсэгт хэлэлцсэн билээ. Харин түүхэн баримтыг сөхвөл хануур засал нь эртний Египетэд 3000 гаруй жилийн өмнө хэрэглэгдэж байснаа бусад улс оронд тархсан (Грийнстон³⁷, 2010: 12-14) гэдэгт өнөөгийн түүхчид санал нэгддэг. Ийнхүү тархах явцад Согдууд хануурын 77 судлыг тодорхойлон нэрлэсэн байх магадлалтай. Учир нь уг 77 судлын олонх нэр төвөд бус үгс болох нь анзаарагддаг. Үүнээс үзэхэд цаг хугацааны хувьд ч хануур заслыг монголчууд бүтээсэн гэж үзэх нь монголын уламжлалт анагаах ухааны түүхийн бичлэгт тохиолдож буй бас нэгэн ташаарал болох нь илэрхий байна.

3.5. Монголын эзэнт гүрэн (XIII зуун)-ий үед холбогдох мэдээлэл

Чингис хаан (1162-1227) эзэнт гүрнээ байгуулж байх үед ч *сог* гэдэг үг урьдын адил баруун зүгийн улсуудыг, ялангуяа Хорезмын улсыг нэрлэж байсан нь тухайн үеийн төвөд эх сурвалжуудад тохиолддогийн нэг жишээ бол Сажа бандида Гунгаажанцан (1182-1251) Годан хаантай уулзаад шавь нартаа бичсэн захидалд тодорхой агуулагдаж байдаг. Уг захидалд Уйгур, Хятад, Тангад, Хор, Согбо зэрэг тухайн үеийн улс орнууд болон ард түмнүүдийн талаар дурдсан ба *согбо* гэсэн нь Монголчуудыг заагаагүй болох нь захидлын дараах хэсгээс илэрхий ажиглагдана. Энд өгүүлэхдээ:

“Уйгурын хаант улс мөхөхөөс өмнө тэрээр (Чингис хаан) хүний өмч хөрөнгийг булаан авч өөрийн гэсэн туслах, сангийн даамал, бу-гаа томилдог байжээ. Тэрээр (Чингис хаан) Хятад, Тангад, Согбо гэх мэтийг мөхөхөөс өмнө (эдгээр хаант улсууд) Монголчуудад (хор) алба гувчуур төлөх ёстой байсан ч түүний хэлсэн үгийг дагаж мөрдөөгүйгээс тэд ялагдах хүлээгээд зугтах газар олдоогүй тул (их хаанд) захирагдахаас өөр аргагүй болсон (Сажа бандида Гунгаажанцан³⁸, 1992: 495)” гэжээ.

Энэ захидалд хор хэмээх үгээр Монголын эзэнт гүрний үед Монголчуудыг нэрлэж байсан ба харин “*согбо*” хэмээх үг нь тэднийг дагаар орсон өөр бусад улс үндэстнийг зааж буй болох нь тодорхой байна. Тэгвэл хэнийг, аль улсыг уг нэрээр нэрлэж байсан болохыг тодруулахаар тухайн үеийн түүхийн үйл явдлуудыг шүүн үзвээс Тангад улс 1038-1227, Хятадад оршин байсан Зүрчидийн Алтан улс 1115-1234 оны хооронд оршин тогтнож байснаа Монголд эзлэгдсэн үйл явдлыг уг захидалд өгүүлсэн бөгөөд *Согбо* хэмээх нэрээр Ираныг хамран оршин тогтнож байсан Хорезмын хаант улс (1077-1231)-ыг нэрлэсэн нь илэрхий.

³⁷ Greenstone

³⁸ sa skya paṇḍi ta kun dga' rgyal mtshan

“Хор” болон “сог” гэсэн үгсийн утгын талаар Ян Мин XIV-XVI зууны үед Түрэгүүдийг *согбо*, Монголчуудыг *хор* гэж төвөд эх сурвалжуудад нэрлэдэг (Ming, 1994: 88–98) гэсэн нь энд өгүүлж буй санааг баталгаажуулах нэгэн баримт юм. Үүнээс үзэхэд тухайн үед уг түүхэн эх сурвалж дахь “хор” хэмээх Монголчууд “согбо” хэмээх ард түмнийг дагаар оруулан захирч байгаа энэхүү мэдээлэл нь анагаах ухааны түүхтэй холбоо бүхий баримтуудад дурдагдах “сог”, “согбо” гэсэн үгсийг Эзэнт гүрний үеийн Монголчуудад хамруулан ойлгох нь ташаарал болохыг илтгэж байгаа юм.

3.6. Баруун монголчууд Төвөдөд (XVII зуун) ноёрхлоо тогтоох үед холбогдох мэдээлэл

Дээрх үйл явдлаас хойш “сог” хэмээх үгээр монголчуудыг нэрлэх болсон нь ойрадууд 1600-аад оны эхэн хагаст Хөх нуурыг эзлэн, улмаар Төвөдөд ноёрхлоо тогтоосон үетэй холбогддог. Энэ тухай Ян Мин³⁹, “Монголчуудыг нэрлэдэг *хор* гэдэг үг нь V Далай ламын бичсэн он дарааллын бичиг болон өөр бусад төвөд эх сурвалжуудад XVII зуунаас эхлэн *Согбо* болон өөрчлөгдсөн” гэжээ (1994: 88-98). Мөн Валентина Пунзи⁴⁰ бичихдээ, XIII зууны эхэн үеийн монголчуудыг ихэвчлэн “хор” гэж нэрлэдэг бол XVII зууны үеийн монголчуудыг “сог(бо)” гэж нэрлэдэг (2017: 268-288) хэмээжээ.

Үнэхээр, Монголын эзэнт гүрэн байгуулагдсанаас эхлээд Хошуудын Төрбайх ноён (1582-1655) Төвөдөд ноёрхлоо тогтоох хүртэлх хугацаанд Монгол болон Монголчуудыг “сог” гэж нэрлэж байсан ямар нэгэн баримт одоогоор тааралдсангүй. Тиймээс Төвөдийн хойд зүгт оршин суух Согдууд түүхийн тавцангаас аажмаар мартагдан алга болсноос хойш уг нэр хэсэг хугацааны дараа шинээр тодрон гарч ирсэн баруун монголчуудад хамаарах болсон гэж үзэж байна. Энэ үеэс “сог”, “согбо” хэмээх нэршлийн уламжлалт утга нь Перс гаралтнууд болох Сака, Согд нарыг заахаас гадна монголчуудыг ч нэрлэх нэр болжээ.

3.7. Өөр бусад улс орнуудтай холбогдол бүхий мэдээлэл

Энэ цаг үед “сог” болон “согбо” гэж нэрлэгдсэн болгоныг Монгол гэж үзэж болохгүй юм. Уг нэршил XVIII зууны үед Төвөдөөс хойш орших Монгол болон баруун зүгийн улсуудыг нэрлэдэг хоёрдмол утгатай байсан нь эх сурвалжуудад тааралддаг. Сүмбэ хамбын “Энэтхэг, Төвөд, Монгол оронд бурхны шашин дэлгэрсэн түүх” (1749) номд Монголыг “сог” гэж нэрлэсэн хэдий ч “Энэтхэгийн баруун зүгт Дили хэмээн нэрлэх Сог орон байна (Сүмбэ хамба⁴¹, 1959: 40)” гэжээ. Эдгээр “согбо” нарыг Миндол хутагт “Энэтхэгийн согбо дор мусульман хийгээд могал зэрэг буй нь лал мөн... Могал, Монгол хоёрыг эндүүрэх нь олон байна (Жамбалчойжидданзанпэрэнлэй⁴², 2013: 135)” гэсэн нь “сог” болон “согбо” гэж нэрлэгдсэн ард түмэн, улс үндэстэн болгон Монгол бус болохыг батлах чухал баримт юм. Улмаар Миндол хутагтын бичсэнийг бататган Зава Дамдин “Энэтхэгийн согбу нь Мусульман хийгээд Моугал зэргээр хэлэгдсэн Лалууд мөн” гээд “өдгөө ихэнх түүхчид Моугал

³⁹ Yang Ming

⁴⁰ Valentina Punzi

⁴¹ Sum pa mkhan po

⁴² Jambalchoijidanpanperenlei

болон Монголын ялгааг эс ялгаснаар эндүүрэл олон гарсан. Тиймээс лалын багш Бранзи Лодой болон түүний залгамжлагч нар Моугал ба харин Тэмүүжин хааны өмөг сэлт нь Монгол мөн тул ялгаж мэдэх хэрэгтэй” гэж маш тодорхой бичжээ (Лувсандамдин, 1964: 13а).

Түүнчлэн, Сүмбэ хамбын (1777) бүтээлд “Хятадын баруунд Хөх нуурын орчимд Ойрад монгол⁴³, Хятад, Амдогоос хойд зүгт сог⁴⁴ язгуурын Монгол⁴⁵ дөчин есөн хошуу, тэрний ард Халх долоон хошуу (Сүмбэ хамба, 2012: 29)” гэх мэтээр *сог* гэж бичсэнээ төвөд үсгээр монгол гэж галиглан бичиж тодруулсан нь тааралддаг. Мөн Миндол номун ханы “Замбутивийн дэлгэр номлол”-д Монголыг Их Монголын орон⁴⁶, Перс буюу Ираныг Барсиг⁴⁷ хэмээн нэрлэсэн байх бөгөөд “*согбо*” хэмээх нэршлээр лалын шашинтан болон түрэг угсааны аймгуудыг нэрлэсэн байдаг. Тухайлбал, “Дээр өгүүлсэн Сэманха (Самарканд) гэхийн зүүн, Дхэвалпур зэргээс зүүн өмнө Могалдхэса буюу *Согбо* хэмээх их орон буй” (Жамбалчойжидданзанпэрэнлэй, 2013: 119) гэх буюу “язгуурын орон Рим лугаа ойр Хархалбак хэмээх *Сог* улс байдаг” (Жамбалчойжидданзанпэрэнлэй, 2013: 113) гэх мэтээр бичжээ. Дээрх эрдэмтдийн бүтээлүүдээр жишээлэн үзэхэд XVIII-XIX зуунд Монгол болон Монголчуудыг төвөд хэлний “*хор*” болон “*сог*” гэсэн хоёр үгээр дуудахын зэрэгцээ “*сог*” нь Төвөдөөс баруун зүгт орших зарим улсуудыг ч мөн адил нэрлэдэг утгаа хадгалж байсан болох нь тодорхой байна.

Чухам ямар учир шалтгааны улмаас Төвөдөөс баруун болон хойд зүгийн улсууд ялангуяа Иран гарал бүхий аймгуудыг нэрлэж байсан “*сог*” хэмээх үг нь баруун монголчуудыг түүхийн тайзнаа гарч ирэхэд анхны утгаа өөрчилсөн нь сонирхолтой асуудал бөгөөд энэ нь тийм ч тодорхой бус. Зарим эрдэмтэд төвөдийн “*сог*” хэмээх энэ үг нь хятад хэлний “*ху*” гэдэг үгтэй адил янз бүрийн гарал угсааны гадаад хүмүүсийг нэрлэдэг (Фан⁴⁸, 1957: 140., Пеллио⁴⁹, 1923: 109) гэсэн нь ортой болов уу. Тиймээс Төвөдийн баруун зүгийн улсууд болон хойд зүгт орших монголчуудыг нийтэд нь уг нэрийн дор хамран ойлгох болжээ гэх үндэслэл урган гарч байна.

Төгсгөлд нь өгүүлэхэд монголын уламжлалт анагаах ухааны түүхийн хөгжлийг ангилсан үечлэлийн II үе шат болох “Эмнэлгийн тусламжийн туршлага хуримтлагдаж, анагаагч эмч бий болсон үе” буюу анхны төрт улс Хүннүгээс (МЭӨ 209 оноос) Их Монгол улс (МЭ 1206 он) хүртэлх хугацааны анагаах ухааны хөгжлийн түүхийн томоохон орон зайг илтгэх жишээгээр сонгон авсан гавлын яс цоолох мэс ажилбар болон хануур эмчилгээ Монголоос гаралтай, түүнчлэн *сог* нэрээр нэрлэгдсэн Налашандир, Галеносын хүү *сог* эмч, *бижи* эмч Замбашилаха болон бусад түүхэн хүмүүс нь монгол хүмүүс байсан (Болд, 2006: 93-128) гэх мэдээлэл ташаарал болох нь бидний болон бусад

⁴³ ao’u rod sog po

⁴⁴ sog

⁴⁵ mon gol

⁴⁶ chen po hor gyi yul

⁴⁷ par sig

⁴⁸ Fang

⁴⁹ Pelliot

судлаачдын судалгааны үр дүн, түүхийн холбогдох баримтуудын хүрээнд нотлогдож байна.

4. Дүгнэлт

Төвөд эх сурвалжуудад тохиолдох XVII зуунаас өмнөх үеийн түүхэнд хамаарах “*сog*” болон “*сogбо*” хэмээх үгсээр эртний Иран гаралтай аймгуудыг нэрлэж байснаа аажмаар утгын шилжилт явагдаж XVII зуунаас төв Азийн улс төр, газар зүйн нөхцөл байдалд баруун монголчууд хүчтэй тоглогч болон гарч ирсэнтэй холбогдон монголчуудыг нэрлэх болсон гэж үзэх үндэслэлтэй юм. Үүний зэрэгцээ монголчуудаас гадна төвөдөөс баруун зүг орших улс, ард түмнүүдийг ч эдгээр нэр томъёогоор нэрлэж байгаа нь уг үгс хоёрдмол утгаа хадгалсаар байгааг илчилнэ.

Түүнчлэн анагаах ухааны түүх, эх сурвалж судлаачид хэт нэг талыг барьсан өрөөсгөл хандлагын үүднээс Монгол, монголчууд гэсэн утгыг чухалчилснаар монгол анагаах ухааны түүхэнд холбогдолгүй зүйлсийг монголчууд хийж бүтээсэн, монгол хүн байсан гэх мэт ташаа тайлбарлаж зарим төөрөгдөл бүхий ойлголтууд бий болгох хандлага гарч байна. Тиймээс XVII зуунаас өмнө үед хамаарах төвөд эх сурвалжийн мэдээлэлд тохиолдох “*сog*” болон “*сogбо*” гэсэн үгсийг тайлбарлахдаа зөвхөн Монгол гэсэн утгыг баримтлалгүйгээр тухайн үеийн орон зай, цаг хугацаанд нь хамааруулан орчуулах нь зүйтэй.

Ном зүй

Монгол хэлээр:

- Батсайхан, Н.** (2021). *Монгол уламжлалт анагаах ухаан: Зарим эх сурвалжийн нягтлан шинжлэл*. Улаанбаатар: Ном Хур хэвлэлийн газар. [Batsaikhan, N. *Mongol ulamjlalt anagaakh ukhaan: Zarim ekh survaljiin nyagtlan shinjlel* [Mongolian Traditional Medicine: Analysis of Some Sources]. Ulaanbaatar: Nom Khur Printing. 2021]
- Болд, Ш.** (2006). *Монголын Анагаах Ухааны Түүх*. Улаанбаатар: Admon. [Bold, Sh. *Mongolyn Anagaakh Ukhaany Tüükh* [History of Mongolian Medicine] Ulaanbaatar: Admon Print. 2006]
- Болд, Ш., Жавхлан, Б.** (2020). *Уламжлалт Анагаах Ухааны 108 Боть: Хүннүгээс Монгол улс хүртэлх үеийн эмч, маарамба, гүүш нарын цадиг, бүтээл*. Боть 1. Улаанбаатар хот: Адмон принт. [Bold Sh., Javkhlan B. *Ulamjlalt Anagaakh Ukhaany 108 Boti*. [108 Volumes of Traditional Medicine: Biography and Creations of Doctors, Maaramba, and Guushs from Xiongnu to Mongolia. (volume 1) Ulaanbaatar: Admon Print. 2020]
- Бүрнээ, Д., Энхтөр, Д.** (2006). *Төвөд-монгол толь*. Улаанбаатар: Admon. [Burnee D., Enkhtur D. *Tövd-Mongol Toli* [Tibetan-Mongolian Dictionary] Ulaanbaatar: Admon Print. 2006]
- Сүхбаатар, О.** (1997). *Монгол хэлний харь үгийн толь*. Улаанбаатар: Admon. [Sukhbaatar O. *Mongol khelnii khari ügiin toli* [Dictionary of Mongolian foreign words] Ulaanbaatar: Admon Print. 1997]

Сумадирадна. (1959). *Төвөд монгол дохионы бичиг нэр утга гурвыг тодруулан харанхуйг арилгагч* зул. Улаанбаатар. Дэвтэр. II, 1193 тал. [sumadiratna. *Tübed mongyol dokiyan-u bičig ner-e üge udqa yurban-i todurayulun qarangqui-yi arilγaγči jula*, Ulaanbaatar. 1959]

Гадаад хэлээр:

Ahmad, Z. (1970). *Sino-Tibetan Relations in the Seventeenth Century*. Rome: Instituto Italiano per il medio ed estremo Oriente. P.110.

Alexey L. Krivoshapkin, Tatiana A. Chikisheva, Alisa V. Zubova, Vladislav P. Kurbatov, Anatoli T. Titov, Pavel V. Volkov. (2014). Scythian Trepanations in the Gorny Altai in Hippocratic Times: Modern Expert Appraisal of Ancient Surgical Technologies. *World Neurosurgery*. 82(5): 649-655.

Bacot, Thomas, and Toussaint. (1940). *In Documents de Touen-houang relatifs à L'histoire du Tibet* (Paris, 1940-6). P.38.

Beckwith, Christopher I. (1979). The Introduction of Greek Medicine into Tibet in the Seventh and Eighth Centuries. *Journal of the American Oriental Society*, 99(2). P. 297-313.

Kitinov, B. (1996). Kalmyks in Tibetan History. *The Tibet Journal*. 21 (3). P. 35-46.

Giraudeau, Pierre-Philippe and François Louis Noël Goré. (1956). *Dictionnaire français-tibétain* (Tibet oriental). Adrien-Maisonneuve. P. 185.

Greenstone G. (2010). The history of bloodletting. *British Columbia Medical Journal*, 52 (1). P. 12-14.

Lhundrop, S., Suzuki, H., and Roche, G. (2019). Language Contact and the Politics of Recognition amongst Tibetans in the People's Republic of China: The rTa'u-Speaking 'Horpa' of Khams. In *The Politics of Language Contact in the Himalaya* edited by Selma K. Sonntag and Mark Turin. Cambridge, UK: Open Book Publishers. P. 17-48.

Edwin, P. (1952). *A Sogdian Colony in Inner Mongolia*, TPXLI 41. P. 317-356.

Hoffmann, Helmut. (1971). The Tibetan Names of the Saka and the Sogdians. *Asiatische Studien*, 25. P. 440-455.

Houston, G. (1974). The Bsam Yas Debate: According to the Rgyal Rabs Gsal Ba'i Me Long. *Central Asiatic Journal* 18 (4). P. 209-216.


Fang, K. Li. (1957). Notes on Tibetan Sog. *Central Asiatic Journal*, 3(2). P. 140.

Pelliot. (1923). "La theorie des quatre fils du ciel," 2. P. 109.

Pope, C, Ziebland, S., and Mays, N. (2006). Analysing qualitative data. In: Pope C, Mays N (eds). *Qualitative Research in Health Care* (3rd edn). Oxford: Blackwell Publishing. P. 63-81.

Punzi, V. (2017). "'Dying Mongol and Being Reborn Tibetan': Otherness and the Integration of Foreigners in the Landscape of Amdo". *Revue d'Etudes Tibétaines*. 42. P. 268- 288.

Tucci, G. (1999) [1949]. *Tibetan Painted Scrolls*. 2 vols., 2nd ed. Bangkok: SDI Publications. P. 128; 256.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.